



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

**Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/503 дугаар захирамж, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/503 дугаар захирамж, А/817 захирамжаар батлагдсан газрын “Дүрэм”-ийн 2.8, 3.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Нийтийн тээврийн үйлчилгээг эрхлэн гүйцэтгүүлэх тухай” гэрээтэй ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагуудын 2019-2020 оны Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар, шалгалт явуулах аж ахуй нэгж, байгууллагуудын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын гаргасан өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээ, үр дүн, цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээ, тайланг сар бүр авч нэгтгэн, биелэлтийн явц байдалтай танилцаж, нэгдсэн шалгалтыг хуваарийн дагуу явуулж дүнг 11 дүгээр сарын 01-ний дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Б.Эрдэнэболд/-д даалгасугай.

3. Ажлын хэсгийн шалгалтад ажиллах тээврийн хэрэгсэлд батлагдсан нормын дагуу шатахууны зардлыг тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Ажлын явц байдалд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.САЙХАНБАЯР

D:\alban khereg\Явсан бичиг-2019\TUSHAAL.docx

1150500353

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2019 оны 12 сарын 17-ний өдрийн
#149 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Б.Эрдэнэболд	Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч
Гишүүд:	О.Батцоож	Тээврийн хяналтын хэлтсийн Автотээвэр Хяналтын Улсын байцаагч
	Э.Сумъяа	Технологийн үзлэг, оношлогооны төвийн инженер
	С.Нямдорж	Тээврийн төлөвлөлт, технологийн Хэлтсийн техник технологийн мэргэжилтэн
	Б.Мөнхзул	Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн
	Ц.Базаррагчаа	Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтсийн салбарын сургалт хариуцсан мэргэжилтэн
	Б.Мягмаржав	Нийслэлийн Онцгой байдлын Гал түймэрийн улсын хяналтын ахлах байцаагч, хошууч
Нарийн бичгийн дарга:	Х.Баасансүрэн	Бүртгэлийн сан хариуцсан мэргэжилтэн

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2019 оны 08 сарын 14-ний өдрийн
114 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Шалгалтын зорилго: Нийтийн тээврийн үйлчилгээний байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах, ажлын явцыг эрчимжүүлэх, өвлийн улирлыг аливаа хүндрэл бэрхшээлгүй өнгөрүүлэхэд оршино.

2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын гүйцэтгэлийн нэгдсэн дүн мэдээг сар бүрийн 01-нд Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэст цаасаар болон цахим хэлбэрээр хүлээн авна. Ажлын гүйцэтгэлийг шалгах хуваарь гарган батлуулж шалгалтыг явуулан нэгдсэн дүнг Даргын зөвлөлийн хуралд Ажлын хэсгийн дарга танилцуулна.

Шалгалтыг доорх чиглэлээр явуулна. Үүнд:

1. Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, дүрэм, стандарт, журмын шаардлагын хүрээнд уг шалгалтыг явуулан холбогдох үүрэг даалгавар, албан шаардлагыг хүргүүлж ажиллана.
2. Байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн гүйцэтгэлийг шалгах;
3. Автобусны дулаан зогсоол стандартын дагуу байгаа эсэх, автобусыг зогсоолд байрлуулах схем, дараалалыг зөв байрлуулсан эсэх, засвар, үйлчилгээний байр болон конторын барилгын засвар, дулаалга, гэрэлтүүлэг, сантехникийн засвар бүрэн хийгдсэн эсэх, зарцуулсан хөрөнгө;
4. Хөдөлмөр хамгаалал, галын аюулгүй байдлын хангалт, гал унтраах багаж хэрэгслийн бүрдэлт, хадгалалт, хамгаалалтын байдал;
5. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний нэгдсэн график төлөвлөгөө гарган биелэлтийг ханган ажиллаж байгаа эсэх,
6. Техникийн засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт, тоног төхөөрөмжийн төрөл;
7. Инженер техникийн ажилтнуудын ажлын хариуцлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын талаар өдөр тутмын үйл ажиллагааны заавар зөвлөмж өгч хэвшүүлсэн эсэх, /автобусны цонх цанталтыг бууруулах, заалны дулааныг нэмэгдүүлэх, УБ смарт картын тоног төхөөрөмжийн ашиглалт гм/;
8. Автобус бүрийн дулаалгын системийн ажиллагаа, аккумулятор /тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийг асааж шалгах/;

9. Хүйтний улиралд үйлчилгээг хэвийн явуулахад шаардагдах автобусны хүрэлцээ, парк шинэчлэлт, нөхөн хангалт хийсэн байдал, зайлшгүй шаардлагатай сэлбэг, шатах тослох материал, хөлддөггүй шингэний нөөцлөлтийн хэмжээ, үнийн дүнг гаргуулах, шатахуун импортлогч компаниудтай гэрээ байгуулан үйлчилгээний тогтвортой байдлыг хангаж буй эсэх;
10. Засвартай удаан хугацаагаар зогсож байгаа тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг диспетчерийн албанаас гаргасан мэдээлэлтэй тулгалт хийх;
11. Замын хөдөлгөөнд техникийн саатлаар зогссон автобусыг чирэх чирэгч автомашиныг болон техникийн түргэн тусламжийн машины техникийн бэлэн байдлыг хангасан эсэх;
12. Боловсон хүчний хангалт, бичиг баримтны эмх цэгц, мэргэжлийн инженер техникийн ажилтан, жолоочийн хангалт, жолоочийг ажлын өвлийн хувцаасаар хангасан байдал;
13. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтэнд нь хяналт тавьж ажиллах;
14. Өвлийн улиралд цас мөсний халтиргаанаас сэргийлж хот дотор зорчих замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлэх, жолоочийн хариуцлагыг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах;
15. Монгол Улсын Засгийн газрын 2018 онд гарсан “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгах, төвийн халаалтанд холбогдоогүй аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг гаргах;
16. Ажлын хэсгийн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаагүй, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцлага тооцох, MNS 5012:2011 стандартын шаардлагуудыг хангаагүй, цаашид үйл ажиллагаа хэвийн явуулах боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагуудын тус газартай байгуулсан гэрээг цуцлах саналыг Даргын зөвлөлийн хуралд танилцуулах;

Нийтийн тээврийн үйлчилгээний газрын
даргын 2019 оны 10 сарын 27-ний өдрийн
Анх дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ШАЛГАХ ХУВААРЬ ГСТ6233

/үндсэн чиглэл/

№	Нэр	Шалгах өдөр	ААНБ-ын хаяг, байршил
1	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТ ҮГ	1-р бааз	Х/01 1-р бааз: ХУД, 3-р хороо, Энгельсийн гудамж, өөрийн байр
2		2-р бааз	Х/01 СХД 19-р хороо, ҮЭ-ийн гудамж
	Зорчигч тээвэр гурав		Х/02 СБД, 2-р хороо, Нарны замд
4	Аз сервис ХХК		Х/02 БГДүүрэг, МҮЭСТөв 114 тоот
5	Блюбус ХХК		Х/03 СХД 20-р хороо, Сонсголлонгийн замд
6	Атибус ХХК		Х/03 ХУД 3-р хороо, Далайбуян компанийн байр
7	Эрдэм транс ХХК		Х/04 БГД, 20 хороо,
8	Автотерминал трейд ХХК		Х/04 ХУД 3-р хороо, Үйлдвэрийн баруун бүс Эрчим хүчний гудамж 60
9	Сайхан ирээдүй ХХК		Х/07 СБД 17-р хороо "Япон цэргийн цогцолбор"
10	Автобус нэгдэл ХХК		Х/07 СХД 9-р хороо, Зүүн салааны эцэст өөрийн байр
11	Сутайн буянт ХХК		Х/08 СХД 20 хороо, өөрийн байр /монгол тээх
12	ГБУС ХХК		Х/08 СХД, 6-р хороо "Ган хийц"-ийн эцэс
13	Тэнүүн Огоо ХХК		Х/09 БГД 20-р хороо, Гурвалжингийн гүүрний баруун талд
14	Тэнүүн огоо 3-р бааз ХХК		Х/09 БЗД 8 хороо, Улаанхуаран данзангийн гудамж Тэнүүн хотхон 37/1
15	Трансбус ХХК		Х/10 БЗД Эрдэнэтолгойн буудал Да хүрээ-17
16	ДЮЦ ХХК		Х/10 СБД 1-р хороо Тээвэрчдийн гудамж ТҮЭТЗ
17	Эмсид ХХК		Х/11 БЗД 23 хороо, Улиастайн эцэст 77 тоот
18	Эс Энд Эй ХХК		Х/11 БЗД-ийн 14-р хороо, Намьянжүгийн гудамж, Зүүн 4-н зам худалдааны төв
19	Мяралзаа ХХК		Х/11 БЗД 12-р хороо Амгалан ТЗЗГ-ын зүүн талд